

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ӨМЧИЙН ХЯНАЛТ, АШИГЛАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**

ИЛТГЭХ ХУУДАС

2022 оны 12 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн
биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

Газрын 2022 онд зохион байгуулах сургалтын болон албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний биелэлтийг Захиргаа санхүүгийн хэлтсийн Хүний нөөцийн Ахлах мэргэжилтэн нэгтгэн ирүүлснийг хүлээн авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалаар тооцож, 6.2.3-т заасан ангилалд шилжүүлэн нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 5.2.1-т заасны дагуу тайлант хугацааг 100%-р тооцож биелэлтийг 0-100 хувиар үнэлсэн болно. Үүнд:

- 6.2.3.1. “Үр дүнтэй”–зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь;
- 6.2.3.2. “тодорхой үр дүнд хүрсэн”–зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-99 хүртэл хувь;
- 6.2.3.3. “эрчимжүүлэх шаардлагатай”–зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 31-69 хувь;
- 6.2.3.4. “үр дүнгүй”–зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг Үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0-30 хүртэл хувь.

Хэрэгжилт, үнэлгээ:

Нэг. Албан хаагчдын сургалтын чиглэлээр:

Байгууллагын хэмжээнд 2022 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг 10 зорилт, сэдвийн хүрээнд төсөвт өртөггүйгээр баталж, хэрэгжүүлэн ажилласан байна.

1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан 40 удаагийн сургалт семинарт албан хаагчдыг хамруулахаар төлөвлөж, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч, ажлын байран дахь сургалтыг 7 удаа зохион байгуулж албан хаагчид бүрэн хамрагдаж, туршлага солилцох арга хэмжээнд 21 албан хаагч, бусад Төрийн албаны зөвлөл, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв, нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан сургалтуудад 47 албан хаагчдыг бүрэн хамруулж, албан хаагчдыг сургалтад хамруулсан байдлаар нийт албан хаагчдад эзлэх хувь 100 хувийн хэрэгжилттэй, нийт 63 албан хаагчаас 8 албан хаагч шилжих, сэлгэх хөдөлгөөнд орсон байна.

2. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны болон төсөвчний анхан шатны сургалт, худалдан авах ажиллагааны мэдлэг олгох анхан шатны болон хяналт шалгалтын чиглэлийн сургалтуудад Засгийн газрын 2021 оны 43, 388 дугаар тогтоолын дагуу хэрэгжих боломжгүй болсон тул байгууллагын сургалтын зардал төсөвт тусгагдаагүйгээс албан хаагчдыг сургах боломжгүй болсон байна.

Хэрэгжилт-“Тодорхой үр дүнд хүрсэн” буюу үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай- 90 хувь

Хоёр.Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

1. Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйл, УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолд заасан журмын дагуу байгууллагын 4 төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгуулах саналаа хүргүүлснээс, 2 албан хаагчид шинээр, 2 албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг ахиулан олгох шийдвэр гаргаж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2 албан хаагчид шинээр, 3 албан хаагчид ахиулан олгосон.

Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэсэн дүгнэлтийг үндэслэн 2022 онд нийт 70,406.6 мянган төгрөгийн ажлын үр дүнгийн шагнал, урамшуулалд олгож, нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл өдөрт 9000 төгрөгөөр бодож олгож, 2022 онд нийт 102,782.9 мянган төгрөг цалин, шагнал урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын төсөвт эзлэх хувь 5 хувьтай байна.

Хэрэгжилт- “Үр дүнтэй буюу зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн” -100 хувь

2.Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэхэд Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу төсвийн хэмнэлттэй ажиллаж, компьютер, тоног төхөөрөмжийн зардалд 10501000 төгрөгийн зардал гаргаж, дэлгэц 2, процессор 2, мауз 2 ширхгийг худалдан авч шинэчлэлт хийсэн.

Хэрэгжилт- “Үр дүнтэй буюу зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн” -100 хувь

3.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд эм бэлдмэл, анхан шатны тусламжийн хэрэгсэл, ковид-19-өөс урьдчилан сэргийлэх эд материалд 737,5 мянган төгрөгийн зардал гаргаж ажилласан.

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд 2 жилд 1 удаа хамруулахаар төлөвлөсний дагуу

2022 оны 04 дүгээр сарын 20-ний өдрөөс 23-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан, нийт 55 албан хаагчийг 7,121,000.0 төгрөгийн зардал бүхий үзлэг, шинжилгээнд хамруулж, эмчийн заавар, зөвлөгөө авч ажилласан байна.

Хэрэгжилт-. "Үр дүнтэй буюу зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн" -100 хувь

4. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр ар гэрт нь гачигдал гарсан 8 албан хаагчид 400,000.0 төгрөгийн тэтгэмж, урт хугацаагаар өвдсөн 4 албан хаагчид 5,000,000.0 төгрөг, галлагаатай гэр, байшинд амьдардаг албан хаагчдын судалгааг шинэчлэн гаргаж, 6 албан хаагчийн гэр бүлд өвөлжилтийн бэлтгэлд зориулан 1,500,000.0 төгрөгний тусламж дэмжлэг үзүүлж, нийт 13,8 сая төгрөгийг албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан байна.

Мөн Улсын их баяр наадам, Ардын хувьсгалын 101 жилийн ой, нийслэл Улаанбаатар хотын 383 жилийн ойн баяруудыг угтаж, нийт 21 албан хаагчийг төрийн одон медаль, салбарын шагналуудад тодорхойлсноос 1 албан хаагч Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор, 10 албан хаагч бусад шагналуудаар шагнагдсан байна.

Хэрэгжилт-. "Үр дүнтэй буюу зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн" -100 хувь

Санал, дүгнэлт:

Газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2022 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн буюу 98,0 хувьтай үнэлэгдэж байна. Цаашид:

1. Байгууллагын төсөвт суугаагүйн улмаас 2022 онд зохион байгуулах боломжгүй болсон төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт, Төсөвчний анхан шатны, худалдан авах ажиллагааны болон монгол бичгийн мэдлэг олгох сургалтуудад дотоод нөөц бололцоогоо ашиглан албан хаагчдыг хамруулж, бусад хэрэгцээт мэдлэг мэргэшил олгох сургалтуудад хамруулах;

2. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг 2023 онд дахин боловсруулан баталж, Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин ажиллаж, хэрэгжилтийг тооцон ажиллах шаардлагатай байна

ХЯНАСАН:
ӨМЧИЙН ХЯНАЛТ, АШИГЛАЛТ
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

П.МАГНАЙБААТАР

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

Ц.ЦЭРЭНДУЛАМ